



**ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА**

2018 оны 02 дугаар сарын 23

№ 01/56 АУА-2018/58/СГА-ТЦЗ

Мандалговь хот

Г

Зөрчил арилгуулах тухай

Г

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1-д тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд Дундговь аймаг дахь Төрийн аудитын газрын 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу Дэлгэрцогт сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар үндсэн цалингийн зардлаас гэрээгээр ажил гүйцэтгэсэн хүнд ажлын хөлс олгосон **424,500.00** /дөрвөн зуун хорин дөрвөн мянга таван зуун/ төгрөгийн зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16.5.5-д /батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах/, Сангийн сайдын 2014 оны 55 тоот тушаалаар батлагдсан “Эдийн засгийн ангилал”-ын /Үндсэн цалин-Цалингийн сүлжээ болон бусад холбогдох эрх зүйн актын дагуу тогтоон олгож байгаа албан тушаалын үндсэн цалин энэ ангилалд багтана/ гэж заасныг зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 15.1.12-т /Аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх, хууль тогтоомж, эрх зүйн хэм хэмжээ тогтоосон бусад шийдвэрийг боловсронгуй болгох саналыг холбогдох байгууллагад тавих/, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2014 оны 138 дугаар тушаалаар батлагдсан Төрийн аудитын байгууллагын ажилтны нийтлэг эрх, үүргийн тухай дүрмийн 2.2.3-т /Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийг хэрэгжүүлэх хүрээнд төрийн аудитын байгууллагын ахлах аудитор, ахлах шинжээч, аудитор, шинжээч нь аудитын явцад илэрсэн төлбөрийг барагдуулах, зөрчлийг арилгуулах зорилгоор төлбөрийн акт, албан шаардлага тавих/, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны 09 дүгээр сарын 09-ны өдрийн А/95 дугаар тушаалаар баталсан Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журмын 4.1.3-д /Төсвийн хөрөнгийг үр ашиггүй, зорилгатай бусаар, батлагдсан хэмжээнээс хэтрүүлэн зарцуулж, Төсвийн тухай хуулийн холбогдох зүйл заалтыг зөрчсөн/ гэж заасныг тус тус үндэслэн ШААРДАХ НЬ:

1. Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;
2. Албан шаардлагыг хэрэгжүүлж, биелэлтийг аймгийн Төрийн аудитын газарт 2018 оны 03 дугаар сарын 25-ны дотор албан ёсоор ирүүлэхийг Дэлгэрцогт сумын Хүүхдийн цэцэрлэгийн төсвийн шууд захирагч Х.Эрдэнэтуяа, нягтлан бодогч Г.Уугантуяа нарт хариуцуулав.

ӨГСӨН<sup>1</sup>:

АУДИТОР

Т.БАТСАЙХАН

**АЛБАН ШААРДЛАГЫГ**

**ЗӨВШӨӨРСӨН:**

ЭРХЛЭГЧ

Х.ЭРДЭНЭТУЯА

НЯГТЛАН БОДОГЧ

Г.УУГАНТУЯА

<sup>1</sup> Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д “Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гэрээсэн албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ” гэж заасны дагуу харуулаач албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.